



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ГОВЬ-АЛТАЙ
АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**



**АЛТАЙ ХОТ
2016 ОН**

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ҮАГ	Үндэсний Аудитын газар
САГ	Санхүүгийн Аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
НА	Нийцлийн аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ШУА	Шинжлэх ухааны акедами
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОБЕГ	Онцгой байдлын Ерөнхий газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ГЗБ	Газар зохион байгуулалт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
МАН	Монгол ардын нам
АН	Ардчилсан нам
МАХН	Монгол ардын хувьсгалт нам

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Үндэсний Аудитын газрын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газар нь 2016 онд Төрийн аудитын тухай хууль болон холбогдох хууль эрх зүйн акт, аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Энэ онд 2015 оны ажлаа дүгнүүлэн “Тусгай” байранд орж Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар “Өргөмжлөл”, “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт үр дүнд” хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан “Шилдэг тайлан”-гаар шалгарч, Үндэсний Аудитын газраас зарласан “Авлигагүй хамт олон” аяны 1 дүгээр шатны шалгаруулалтанд амжилттай оролцон “ӨРГӨМЖЛӨЛ”-өөр шагнууллаа.

Үндэсний аудитын газрын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газар нь 2016 оныг “Аудитын байгууллагын ажилтнуудын мэдлэг, мэргэшил, аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх” жил болгон зарлаж, батлагдсан төсөв 265.6 сая төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 бүлэг 52 нэрийн ажилд хуваарилан өртөг тооцож, аудитын төсөв 16.1 сая төгрөг нийт 281.7 сая төгрөгийн өртөгтэйгээр хийж гүйцэтгэхээр төлөвлөж, 17 орон тоотойгоор тавьсан зорилтоо хэрэгжүүлэн ажиллалаа.


Төлөвлөсөн 52 асуудлаас 49 асуудал бүрэн хэрэгжиж, ҮАГ-аас бүсийн сургалтыг зохион байгуулаагүй, 1 аудитад хамрагдах асуудал манай аймагт хэрэгжээгүй тул аудит хийгдээгүй, 1 аудит 2017 онд хийхээр үйл ажиллагааны тайланд өөрчлөлт оруулж баталсан, төлөвлөгөөнд тусгагдаагүй 5 аудитыг хийж төлөвлөгөөний биелэлт 110 хувиар биелжээ.

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт, үр дүнд хийх аудитад хамрагдах асуудал аймагт хэрэгжээгүй тул хийгдээгүй, аймгийн ИТХ-ын захиалгаар хийгдэх Төрийн албан хаагчийн хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хийх аудитыг 2017 онд шилжүүлсэн.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй Сонгуулийн тухай хуулийн дагуу аймаг, орон нутгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн аудит, аймаг, сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвших нам эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох, нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд нийцлийн аудитыг хийлээ.

Аудитын газар нь 2016 онд 190 санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитыг, нэгдсэн төлөвлөгөөгөөр гүйцэтгэлийн аудит 4, нийцлийн аудит 6, үйл ажиллагааны төлөвлөгөөнд хийсэн аудитаар 48,795.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 11,024.5 сая төгрөгийг залруулж, 33,169.5 сая төгрөгийн зөрчилд 185 албан тушаалтанд зөрчил арилгуулах албан шаардлага, 3,225.2 сая төгрөгийн зөрчилд 75 заалт бүхий зөвлөмж өгч, 1,377.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Ажлын хариуцлага алдсан 101 ажилтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлснээс 91 албан тушаалтанд хариуцлага тооцсон хэрэгжилттэй байна.



Аудитаар 2016 онд шинээр 6,624.5 сая төгрөгийн үнэлгээ бүхий 182 санхүүгийн үр өгөөж, 218 санхүүгийн бус үр өгөөж бий болгохоор бүртгэж, өмнөх оноос шилжиж ирсэн

шийдвэрийн хэрэгжилтийн хамт 4,638.9 сая төгрөгийн үнэлгээ бүхий 146 санхүүгийн үр өгөөж, 197 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллгуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

Санхүүгийн болон нийцлийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангах хүрээнд хариуцагч байгууллагаас шүүхэд Есөнбулаг, Эрдэнэ, Баян-Уул, Төгрөг сумдын “Сум хөгжүүлэх сан”-тай холбоотойгоор нийт 87.6 сая төгрөгийн нэхэмжлэл гарган шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.



Аймгийн аудитын газар нь хийж гүйцэтгэсэн аудитын тайлан холбогдох мэдээллийг хууль, журамд заасан хугацаанд AUDIT.MN нэгдсэн цахим хуудсанд, шилэн дансны хуульд заасан мэдээллийг SHILENDANS.MN цахим хуудсанд бүрэн байршуулж ирлээ.

Мөн үйл ажиллагааны тайлан, аудитын тайлан, холбогдох шийдвэрийг аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт албан тоотойгоор хүргүүлсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР:

Аудитад хамрагдах санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөхөд энэ аудитын зорилт оршино.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаалаар 199 байгууллагын 275 санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийхээс 136 санхүүгийн тайланд аймгийн аудитын газрын аудитор, шинжээч нар, 60 санхүүгийн тайланд хувийн аудитын компаниар гэрээний үндсэн дээр аудит хийлгэхээр, ТЭЗ-ийн нэгтгэсэн тайлангаар 77 санхүүгийн тайланд түүвэр хийж үзэхээр, 2 санхүүгийн тайланд итгэл үзүүлэхээр батлагдсан.

Уламжлалт анагаах ухааны төв, Олон нийтийн “Алтай” радио ОНӨААТҮГ нь Итгэл үзүүлэх журамд заасан шалгуурыг хангасан.

Аудитын газрын хэмжээнд 196 санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг хийж дүгнэлт гаргахаас төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 санхүүгийн тайлан, шууд захирагчийн 141 санхүүгийн тайлан, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 20 санхүүгийн тайлан, 20 төсөл сан хөтөлбөр, 8 төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн нийт 190 санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа. Үүнээс 57 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг хувийн аудитын компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.

Тагнуулын хэлтэс, ШУА-ийн Одон орон, Геофикикийн Хүрээлэнгийн Говь-алтай аймаг дахь салбарын тайланг нэгдсэн тайланд хамруулан ҮАГ-ын санхүүгийн аудитын газар хийж гүйцэтгэсэн.

Харин Бигэр сумын Цэцэрлэг, Халиун сумын Цэцэрлэг, Цогт сумын Баянтоорой тосгоны Цэцэрлэг, Орон сууцны алба ОНӨААТҮГ-ууд нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.3 дахь заалтад заасан хугацаанд санхүүгийн тайлангаа хувийн аудитын байгууллагад ирүүлээгүйгээс аудит хийгдээгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитыг 13 хүн 1273 хүн өдөр, 6778 илүү цагаар ажиллаж гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар 94 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт, 86 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 10 санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 28,920.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 11,021.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулан, 1,276.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,671.1 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 2,951.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж, 4,937.1 сая төгрөгийн санхүүгийн, 95 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэж, 4,109.4 сая төгрөгийн санхүүгийн, 95 санхүүгийн бус, өмнөх оноос шилжин ирсэн 31.6 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

Мөн төсвийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, хөрөнгийн тооллого хийдэггүй, тооллого хийсэн ч чанар муутай зохион байгуулдаг, хоол хүнс бараа материал, шатахууны тайлан гаргадаггүй, их хэмжээгээр нөөцөлдөг, төсөв хэтрүүлсэн, төсвийн хэлбэлзлийг зөрүүтэй тайлагнасан аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, өмнөх жилд гаргасан алдаа зөрчлийг давтан гаргасан, менежер, нягтлан бодогч, эд хариуцагч, бусад холбогдох хүмүүс зэрэг нийт 76 албан тушаалтанд хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэнд хариуцлага тооцуулахаар эрх бүхий байгууллагад албан шаардлага хүргүүлж хэрэгжүүлэн ажиллалаа.

Бид Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлага, 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудит хийхэд баримтлах бодлого, аудитаар илэрсэн алдаа, зөрчилд өгөх шийдвэрийн төслийг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Завсрын аудитаар:

ҮАГ-ын харьяа Говь-Алтай аймгийн Аудитын газрын 2016 оны ажил үйлчилгээний төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2015 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 240 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ын дагуу Санхүүгийн тайлангийн Завсрын аудитыг 30 байгууллагын 05 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд хийлээ.

Завсрын аудитаар нийт 240.2 сая төгрөгийн төлбөр зөрчил илрүүлж 12 албан тушаалтанд 120.9 сая төгрөгөнд зөрчилд арилгуулах албан шаардлага, 119.3 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлж, 42.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Аймгийн Аудитын газар нь 2016 онд УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, Үндэсний Аудитын газрын төлөвлөгөө, хөтөлбөрөөр Нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, Улсын нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэлд гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Гүйцэтгэлийн аудитаар 9 аудитор, шинжээч нар 113 хүн өдөр, 582 илүү цаг ажиллаж гүйцэтгэсэн байна.

Гүйцэтгэлийн аудитаар 1,860.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 26.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,833.7 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, 51.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бүртгэлээ. Өмнөх оноос шилжин ирсэн 5 зөвлөмж, 62.4 сая төгрөгийн актыг барагдуулж, 101.0 сая төгрөгийн санхүүгийн, 5 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

3.1 Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын талаар:

Гүйцэтгэлийн аудитаар УТХО, ОНТХО-ыг үзэж дүгнэлт гаргаж, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг цахимд хуудсанд шивж орууллаа.

Улсын төсвөөс хэрэгжиж байгаа 19 хөрөнгө оруулалтын ажлууд нь аймаг орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа хэдий ч түүний ажлын явц хэтэрхий удаашралтай байна. Эрх шилжиж ирсэн 6 хөрөнгө оруулалтын ажлаас 1 ажил буюу

Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн их засварын ажил бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд бусад ажлын тухайд 30-80 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 27 хөрөнгө оруулалтын ажлыг 2,991.2 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Дээрх ажлуудын 14 ажил нь шинээр хийгдсэн ажил бөгөөд, 7 ажил нь өмнөх оноос шилжин ирсэн, 6 ажил нь хугацаа хойшлогдсон хөрөнгө оруулалтын ажлууд байна.

Аудитаар **“Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилт хангалтгүй, хөрөнгө оруулалтын ажлууд удаашралтай байна. Мөн орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлууд гэрээт хугацаандаа хийгдэхгүй, ихэвчлэн гэрээг сунгаж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хүртэх хугацааг удаашруулж байна”** гэсэн дүгнэлт өгч 749.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж 11.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 737.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 5 албан тушаалтанд 7 заалт бүхий албан шаардлагыг хүргүүлж 11.8 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж бий болгохоор бүртгэж албан шаардлагыг 100 хувь биелүүлэн ажиллаа.

3.2 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын талаар

Аудитаар аймгийн орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа бусад баримт материалд тулгуурлан аудит хийлээ.

Аймгийн аудитын газар нь Говь-Алтай аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийхээс өмнө Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу бүх шатны төсвийн захирагч болон орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд аудит хийж дүгнэлт гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар **“Орон нутгийн орлого, төсөвт байгууллагуудын төсвийн төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөн, орлого зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж ажиллах шаардлагатай байна”** гэсэн дүгнэлт өгч 951.6 сая төгрөгийн зөрчил илэрч 3 албан тушаалтанд 4 заалт албан шаардлага хүргүүлж УАГ-ын ГАГ-т 3 санал уламжилж 25.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг бий болохоор бүртгэж, 25.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

1.3 Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтын аудитын талаар:

Аудитад ОБЕГ-ын харьяа Говь-Алтай аймаг дахь Улсын нөөцийн салбарын 2015 оны үйл ажиллагаа, 2016 оны 4 сарын 30-ны өдөр хүртлэх үйл ажиллагааг хамруулан улсын нөөцийн бараа материалын бүрдүүлэлт, тендер шалгаруулалт, нөөцийн бараа материалыг шинэчлэх, сэлгэх, хадгалалт, хамгаалалт, бүртгэл тайлагнал, улсын нөөцийн бараа материалын зарцуулалт, тайлант хугацаанд хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагаа, шийдвэр гаргалт, тэдгээрийн үр нөлөө, хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ, ажлын баримт материал, хөндлөнгийн хараат бус байгууллагын судалгаа, шинжилгээний үнэлгээ дүгнэлтийг хамруулан шалгалаа.

Аудитаар **“Улсын нөөцийн салбарын нөөцийн барааны бүрдүүлэлт, зарцуулалт, хадгалалтад тавих дотоод хяналтыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна”** гэсэн дүгнэлт өгч 110.3 сая төгрөгийн зөрчил илрүүлж 7.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2 албан тушаалтанд 103.1 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж 7.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж бий болгохоор бүртгэж, 7.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

1.4 Монгол Улсын Их Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэлийн аудитын талаар:

Аудитаар Говь-Алтай аймгийн Сонгуулийн хороо, сумын сонгуулийн хороод, Улсын бүртгэл, Статистикийн газар, Цагдаагийн газарт улсын төсвөөс олгосон сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалуудыг хамруулан Сонгуулийн тухай хууль, “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан сонгуулийн зардлын тооцоо судалгааг гарсан зардалтай харьцуулж гүйцэтгэлийг хянан, аймгийн болон сумдын сонгуулийн хорооны харилцах дансны хуулгыг анхан шатны баримтаар давтан тооцоолол

хийж боловсруулан, холбогдох байгууллагуудтай байгуулсан гэрээ түүний биелэлтийг түүвэрлэн үзсэн.

Аудитаар **“Анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, НББ хөтлөөгүй, үе шатны хяналт хангалтгүй байсныг эс тооцвол сонгуулийн зардлыг үр дүнтэй зарцуулжээ”** гэсэн дүгнэлт өгч 49.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж 7.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2 албан тушаалтанд 41.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж 5.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж бий болгохоор бүртгэж, 5.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Аймгийн Аудитын газар нь УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, Үндэсний Аудитын газрын төлөвлөгөө, хөтөлбөрөөр Шилэн дансны хуулийн хэрэгжилт, ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн, Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, Орон нутгийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд нийцлийн аудитыг хийлээ. Нийцлийн аудитыг 5 хүн 179 хүн өдөр, 1887 илүү цаг ажиллаж гүйцэтгэсэн байна.

Нийцлийн аудитаар 12,235.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 55.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12,171.0 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж, 433.3 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 103 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэж, 205.3 сая төгрөгийн санхүүгийн, 94 санхүүгийн бус үр өгөөж, өмнөх оноос шилжин ирсэн 109.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 21 ажилтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлснээс 13 албан тушаалтанд хариуцлага тооцсон хариу ирсэн байна.

4.1 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын талаар:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан дүнг УИХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

МУ-ын УИХ-аас 5,733.8 сая төгрөгийг аймгийн ОНХС-д олгохоор төлөвлөж баталсан бол, аймгийн ИТХ шилжих үлдэгдлээс 239.0 сая төгрөгийг, 129.0 сая төгрөгийг хайгуулийн лицензийн төлбөрөөс ОНХС-д оруулахаар нийт 6,101.0 сая төгрөгөөр тооцож баталжээ.

Аймгийн хэмжээнд нийт 18 сум, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг газар дээр нь очиж үзлээ.

Аудитаар **“ОНХС-гаас 30.6 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулсан, дотоодын хяналт хангалтгүй байгааг эс тооцвол аймгийн хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгасан бүтээн байгуулалтын ажлууд хийгджээ”** гэсэн дүгнэлт өгч 3,541.1 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн 54.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3,063.4 сая төгрөгийн зөрчилд 82 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага, 423.7 сая төгрөгийг зөрчилд 16 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг холбогдох байгууллага болон албан тушаалтанд хүргүүлжээ.

Аудитаар 275.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 79 санхүүгийн үр өгөөж бүртгэж 47.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 75 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

4.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитын талаар /2016 оны I улирлын байдлаар/:

Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасны дагуу хамрагдах 211 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс 210 байгууллага нь шилэн дансны нэгдсэн систем болох www.shilendans.gov.mn сайтад өөрийн цэсийг нээлгэсэн байна.

Аймгийн хэмжээнд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг мэдээлбэл зохих 203 байгууллага байгаа бөгөөд 1 дүгээр сард-2 /Баян-Уул сумын нэгдсэн, Хөхморьт сумын ИТХ/, 2 дугаар сард-3 /Баян-Уул сумын нэгдсэн, Бугат сумын дунд сургууль, Жаргалан

сумын нэгдсэн/, 3 дугаар сард 8 /Баян-Уул сумын нэгдсэн, Бугат сумын ИТХ, дунд сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төв, Тахийн талын багийн бага сургууль, ГИДЦГХЗ “Б” хэсэг/ байгууллага нь мэдээлээгүй байна.

Аудитаар **“Аймгийн хэмжээнд шилэн дансны тухай хууль зохих түвшинд хэрэгжиж байна”** гэсэн дүгнэлт өгч 2,540.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж 2 санхүүгийн бус үр өгөөж бүртгэж харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөршүүллээ.

Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газарт “Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэсийг хуульд нийцүүлэн боловсронгуй болгох” саналыг хүргүүлсэн.

1.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудитын талаар /2016 оны III улирлын байдлаар/:

Аймгийн хэмжээнд хуулийн 3.1.1-3.1.5-д заасан нийт 223 байгууллага байгаа бөгөөд эдгээр байгууллагын дансны хуулга, тушаал шийдвэрийг нэгдсэн цахим хуудсанд оруулсан мэдээлэлтэй тулган баталгаажуулж, аудитыг гүйцэтгэсэн.

Орон нутгийн өмчит хуулийн этгээдээс Барилга захиалагчийн алба 2016 онд үйл ажиллагаа явуулаагүй байна.

Бүтцийн өөрчлөлтөөр Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсүүд 2016 оны 09 дүгээр сард нэгдсэн тул нэгдэхээс өмнөх 1-8 сарын байдлаар мэдээллийг үзсэн бөгөөд нэгдсэний дараа 9 сарыг хамруулан үзсэн.

Мөн Улсын бүртгэл, статистикийн хэлтэс нь 2016 оны 02 дугаар сард нэгдсэн бөгөөд 9 дүгээр сарын байдлаар тусдаа цахим хуудастай болсон тул тус тусад нь хамруулан үзсэн болно.

Тус аудитыг 5 сард хийсэн бөгөөд өмнөх аудитаар илэрч байсан төсвийн гүйцэтгэлийг тухайн сард нь дутуу мэдээлсэн байсан.

Шилэн дансны тухай хууль, журам, нэгдсэн цахим хуудасын уяалдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

Аудитаар **“Аймгийн хэмжээнд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 69% байна”** гэсэн дүгнэлт өгч нийт 5,924.4 сая төгрөгийг зөрчлийг илрүүлэн 1 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага аймгийн Засаг даргад, Үндэсний аудитын газарт 2 заалттай саналыг хүргүүлж 3 санхүүгийн бус үр өгөөж бүртгэж, 3 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлэн ажиллаа.

1.4 Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын талаар:

Говь-Алтай аймагт Байгаль орчныг хамгаалах сан, Сургалтын төрийн сан, Зэвсэгт хүчний сангууд байхгүй бөгөөд зөвхөн Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тэтгэлэгийн зардал тус аудитад хамрагдсан болно.

АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуульд 120.0 сая төгрөгийн тэтгэлэг олгохоос 80.0 сая төгрөгийн тэтгэлэгийг суралцагчдад олгож 40.0 сая төгрөгийн өглөгтэй байна.

Аудитаар Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуулиудын хичээлийн 2014-2016 оны журнал ирцийн бүртгэлийг Хөдөлмөрийн яамнаас тэтгэлэг олгосон банкны хуулгатай тулгалт хийж зөрүүг тооцлоо.

Аудитаар **“Мэргэжлийн боловсролын сургалтыг дэмжих сангийн хуулийн хэрэгжилт зохих түвшинд хэрэгжиж, зорилтод бүлэгт чиглэгдэн үр дүнгээ өгч байгаа хэдий ч дотоод хяналт хангалтгүй байна”** гэсэн дүгнэлт өгч 35.5 сая төгрөгийг зөрчлийг илрүүлэн 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 35.1 сая төгрөгийн зөрчилд 3 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага, 1 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуулийн захиралд хүргүүллээ.

Аудитаар 20.0 сая төгрөгийн санхүүгийн, 1 санхүүгийн бус үр өгөөж бүртгэж, 20.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 1 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүллээ.

1.5 Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын талаар:

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар БОАЖЯ, түүний харьяа байгууллагууд, аймаг, сумдын ИТХ, бүх шатны Засаг дарга түүний харьяа байгууллага, бүх шатны татварын байгууллага, холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдийг хамруулан тэдгээрийн 2015 оны ажлын тайлан, статистик мэдээ, судалгааны материалд тулгуурлан газар дээр нь үзэж ярилцлага хийж аудитыг гүйцэтгэсэн. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэнд хийх энэ аудитад газар, түүний хэвлий дэх нөөц хамрагдаагүй болно.

Аудитаар **“Усны нөөцийн ашиглалт, түүнээс оруулах орлогын төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна”** гэсэн дүгнэлт өгч 168.0 сая төгрөгийг зөрчлийг илрүүлэн, 1 заалт зөвлөмж, 168.0 сая төгрөгийн зөрчилд 14 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага, 4 аж ахуй нэгжид хариуцлага тооцох санал хүргүүлээ.

Аудитаар 115.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 15 санхүүгийн үр өгөөж бүртгэж 115.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 10 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

1.6 Орон нутгийн сонгуулийн зардлын нийцлийн аудитын талаар:

Говь-Алтай аймгийн Сонгуулийн хороо, сумын сонгуулийн хороод, Улсын бүртгэл, Статистикийн газар, Цагдаагийн газарт улсын төсвөөс олгосон сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалуудыг хамруулан үзлээ.

Аудитаар **“Хоолны зардлыг илүү тооцож олгосныг эс тооцвол сонгуулийн зардлыг үр дүнтэй зарцуулжээ”** гэсэн дүгнэлт өгч 24.4 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2.5 сая төгрөгийн алдааг залруулж, 0.6 сая төгрөгөнд төлбөрийн акт тогтоож, 15.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 6.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар 22.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 3 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэж, 22.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 3 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

1.7 Нам, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд хийсэн нийцлийн аудитын талаар:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд 4 нам, бие даагч нийт 118 нэр дэвшигч оролцсон бөгөөд Сонгуулийн хорооны 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 158 дугаар албан бичгээр сонгуульд оролцсон 3 намын 77 /АН-ын 41, МАН-ын 35, МАХН-ын 1/ нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна. Харин 41 /МАН-ын 3, МАХН-ын 30, ХҮН-ын 3, бие даагч 5/ нэр дэвшигч нам, эвслүүдийн зардлын тайлан ирүүлээгүй болно.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчдэд 2.0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн хуулийн этгээд байхгүй, харин 1.0 сая төгрөгөөс дээш хандив өгсөн 45 иргэнээс 73.8 сая төгрөг төвлөрснийг нийтэд зарлалаа.

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй аудитын талаар:

1.8 Аймаг, орон нутгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн аудитын талаар:

Аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд Монгол ардын нам, Ардчилсан нам, Монгол ардын хувьсгалт нам, ХҮН нам, 6 хувиараа нэр дэвшигчээс ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17, Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн аудит хийхэд хуульд нийцээгүй 16 зорилт арга хэмжээ тусгагдсан байсан.

Аудитаар 4 нам, 2 хувиараа нэр дэвшигчид 16 заалт бүхий албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллалаа.

1.9 Орон нутгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн аудитын талаар:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд 3 намын 54, бие даагчийн 71 нийт 125 Сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргалаа.

Орон нутгийн ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөртөө Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4.1, 67.4.4, 67.4.5 дахь заалтуудад

нийцэхгүй зорилтыг дэвшүүлсэн 35 нам, бие даагч нарт 76 заалт бүхий албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгуулан дүгнэлт өгсөн болно.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсээс дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг ирүүлээгүй тул санхүүгийн эх үүсвэр шаардсан зорилтуудын хэрэгжүүлэх эх үүсвэрийн байдалд хяналт хийж чадаагүй болно.

ТАВДУГААР БҮЛЭГ: ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮСЭЛТ БОЛОН ӨӨРИЙН САНААЧЛАГААР ХИЙСЭН АУДИТЫН ТАЛААР:

Аймгийн Аудитын газар нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын захиалгаар Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалтын үр дүнд гүйцэтгэлийн аудит, “Газрын тухай хууль, түүнтэй холбоотой бусад хууль Эрх зүйн актын хэрэгжилтийн үр дүнд нийцлийн аудит хийлээ. Тус аудитыг 5 хүн 237 хүн өдөр, 272 илүү цаг ажиллаж гүйцэтгэсэн байна.

Аймгийн ИТХ-ын захилагат аудитаар 5,779.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 19.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,493.2 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 266.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлж, 1,201.2 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 15 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэж, 82.6 сая төгрөгийн санхүүгийн, үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

Аймгийн ИТХ-ын захилгаар хийсэн аудитын шийдвэрийг биелүүлэх хугацаа болоогүй тул хэрэгжилт болоод үр өгөөжийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй болно.

1.1 Газрын тухай хууль, түүнтэй холбоотой бусад хууль эрх зүйн актын хэрэгжилтийн аудитын талаар:

Аймаг Говь-Алтай аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүд, сумдын газрын даамлуудыг 2014, 2015, 2016 оны 12 дугаар сар хүртэлх аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Алтай хот, сумдын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, газрын нэгдмэл сангийн тайлан, аймаг, сумдын Засаг даргын захирамж, шийдвэрүүд, газар эзэмшигчдийн хувийн хэрэг, газар олголт чөлөөлөлт, газрын төлбөрийн судалгаа, бусад шаардлагатай материалуудыг гаргуулав. Сумдын газрын даамлуудыг аймгийн төвд ирүүлэн улсын бүртгэл, хувийн хэрэг, Засаг даргын захирамжийн хүрээнд шалгасан.

Аймгийн хэмжээнд 2014-2016 онуудад нийт ГЗБ-ын жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд 751.69 га газрыг 921 иргэн, ААНБ-д, төлөвлөсөн байршил, хэмжээнээс илүү 143.8 га газрыг 523 иргэн, ААНБ-д олгожээ.

ГХБХБГ, сумдын газрын даамал нар нь иргэнд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээс бусад тохиолдолд дуудлага худалдаа, сонгон шалгаруулах зарчмыг баримтлахгүйгээр 2014-2016 онуудад нийт 1,299.4 га газрыг 117 иргэн, ААНБ-д худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн зориулалтаар үнэ төлбөргүйгээр олгож хууль зөрчсөн байна. Үүнийг дуудлага худалдааны анхны үнээр тооцож үзэхэд 875.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Аудитаар 2014-2016 онуудад гарсан Засаг даргын захирамжийн хүрээнд газар шинээр олгосон, эрх шилжсэн, хүчингүй болсон, нэр, хаяг өөрчлөгдсөн, хугацаа сунгасан, зориулалт өөрчилсөн зэрэг хөдөлгөөнийг газрын улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг судалж үзэхэд 1444 иргэн, ААНБ-ын 970.3 га газрын мэдээллийг нэмж оруулаагүй, 50 иргэн, ААНБ-ын 8.9 га газрын мэдээллийг давхар бүртгэсэн, Засаг даргын захирамж гараагүй байхад 5 иргэнд 1 га газрын мэдээлэл оруулсан, 15 иргэн, ААНБ-ын 6.3 га газрын талбайг зөрүүтэй оруулсан, 1389 иргэн, ААНБ-ын 1304,5 га газарт гэрчилгээ олгож, гэрээ байгуулаагүй байна.

Өмчлөлийн улсын бүртгэлийг хувийн хэрэгтэй тулгахад Засаг даргын захирамж гарч газар өмчлөх эрх үүссэн боловч 125.5 га талбайн 1266 нэгж талбарт хашаа огт хатгаагүй, кадастрын зураг байхгүй, өмчилсөн талбарыг давхардуулан 6 иргэнд 1.6 га газрыг олгосон, 65 иргэнд үнэгүй өмчлөх эрхийг 2 дахь удаагаа эдлүүлж 51.9 га газрыг олгосон, нэг талбарт давхар захирамж гарган 95 иргэний 71.7 га газрыг мэдээллийн санд давхардуулсан, 66.2 га талбай бүхий 715 иргэний хувийн хэрэг огт байхгүй. Газар өмчлөлийн эрхийн хувьд 236.6 га талбай бүхий 2609 иргэн өмчлөлийн гэрчилгээ огт аваагүй.

Бусад аудитаас онцлох ялгаа: Энэ аудитыг аймгийн төв болон бүх сумдыг хамруулсан бөгөөд бодит байдалд дүгнэлт өгөхөөс гадна боломжит эх сурвалжийг олох,

шийдвэрлэх арга замыг олж тогтоох судалгаа шинжилгээний ажил нэлээд хийгдсэн нь давуу талтай юм.

1.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн 2014-2016 оны бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт үр дүнд хийсэн аудитын талаар:

Аудитаар Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газар, Бэлчээр ашиглалтын холбоо, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Хүнс хөдөө аж ахуйн газар, Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалт, Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Каритас монгол сан, сум аймгийн төвийн тусгай зориулалттай болон нийтийн үйлчилгээний байгууллага, Норвегийн тусламжийн байгууллагуудын ирүүлсэн судалгааг үндэслэн аймгийн төвийн 25 байгууллагад хэсэгчилсэн, 4 байгууллагад бүрэн тооллого хийж, орлого авсан хөрөнгө оруулалтыг төрийн болон орон нутгийн өмчийг мэдээлэлжүүлэх программд шивсэн файлтай тулган зөрүүг холбогдох байгууллагын албан тушаалтанд танилцуулан баталгаажуулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

Бусад аудитаас онцлох ялгаа: Энэ аудитыг аймгийн хэмжээнд хийгдэж байгаа хөрөнгө оруултын эх үүсвэр, хөрөнгийн хэмжээг, ашиглагдахгүй байгаа хөрөнгө оруулалт, данс бүртгэлд тусгасан эсэхэд дүгнэлт өгөхийг зорьсон.

Аудитаар “Хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт түүнд тавих хяналт хангалтгүй байна” гэсэн дүгнэлт өгч 4,238.1 сая төгрөгийг зөрчлийг илрүүлэн, 4 заалт зөвлөмж, 6.5 сая төгрөгийн акт тогтоож, 4,231.6 сая төгрөгийн зөрчилд 5 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага, 3 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлээ.

Аудитаар 6.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 3 санхүүгийн бус үр өгөөжийг өгөөж бий болгохоор бүртгэлээ. Аудитаар 3 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлээ.

1.3 Орон нутгийн төсвийн төсөлд өгөх санал:

Орон нутгийн төсөвт орлого нэмэгдүүлэх саналаар 606.7 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх 5 саналыг аймгийн ИТХ-д хүргүүлсэн байна. Тус саналыг 2017 оны төсвийн орлогыг нэмэгдүүлэхээр аваагүй хэдий ч тухайн орлого орох бүрд төсөвт тодотгол хийж хүлээн авахаар боллоо.

1.4 ИТХ-д өгсөн зөвлөмж, шаардлагын талаар:

Аймгийн ИТХ-ын захиалгаар “Газрын тухай хууль, түүнтэй холбоотой бусад хууль эрх зүйн актын хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар аймгийн ИТХ-д 2 заалт бүхий зөвлөмж, Засаг даргад 6 заалт бүхий зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын захиалгаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн 2014-2016 оны бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн ИТХ-д Хөрөнгийн хэрэгцээ шаардлага судлан үзэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг дагуу шийдвэр гаргаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-аас зөвлөмж, албан шаардлагын дагуу аудитаар илэрсэн зөрчил, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцүүлэг зохион байгуулж холбогдох байгууллага, албан тушаалтан нарт хугацаатай үүрэг даалгавар өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг байгууллага бүрээр гарган хэрэгжилтийг хангуулах талаар адитын мэдэгдэл хүргүүлснийг дагуу аймгийн Засаг дарга шийдвэрийг хэрэгжилтийг хангаж ажиллах талаар төсвийн менежер нарт хугацаатай үүрэг даалгавар өгсөн ажиллаж байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ: ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө 110 хувиар биелсэн байна.

Тэргүүлэх аудитор Ерөнхий аудитортой, аудитын менежер, аудитор, шинжээч нар Тэргүүлэх аудитортой үр дүнгийн гэрээ, Үйлчилгээний ажилтнууд Тэргүүлэх аудитортой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллалаа. Хагас бүтэн жилээр аудитор, шинжээч нарын үр дүнгийн гэрээний биелэлтийг илтгэх хуудсаар дүгнэлээ.

Энэ онд Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов А-43, Б-7 тушаал гарч явсан бичиг-361, ирсэн бичиг-289 бүртгэгджээ. Хариутай албан бичиг, өргөдөл хүсэлтийг цаг тухай бүрд шийдвэрлэж ажиллалаа.

Ажилтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргуулан тайлан мэдээг хүргүүлсэн. Мөн аудит хийх тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг, шаардлагатай үед нууцын баталгааг гаргуулан баталгаажуулж ажилласан.

Орон нутагт зохион байгуулсан санхүүгийн ажилтнуудын зөвлөгөөнд 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн СТА-ын талаар мэдээлэл хийж цаашид авах арга хэмжээ, зөрчил дутагдлыг арилгах тухай зөвлөмж өглөө.

Аймгийн ЗДТГ-ын захиалгаар шинээр томилогдсон ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт төрийн аудитын байгууллага түүний чиг үүрэг, төрийн аудитын тухай хууль, төсвийн тухай хууль, аудитын төрөл, сумдад хийсэн аудитаар илэрсэн зөрчил дутагдал цаашид анхаарах асуудлын талаар сургалт зохион байгууллаа.

Сумдын Санхүүгийн албадын дарга нарт энэ оны болон өмнөх оноос шилжиж ирсэн шийдвэрийн хэрэгжилтийн мэдээллийг хийж зөрчил арилгах арга зам, цаашид анхаарах асуудлаар зөвлөгөөн хийж мэдэгдэл хүргүүллээ.

Санхүүгийн тайланд гэрээний үндсэн дээр аудит хийлгэх хувийн аудитын компанийг сонгон шалгуулах үнэлгээний хороо “Цэгцтөв богд аудит”ХХК, “Кординат аудит” ХХК-ныг шалгаруулан Монгол Улсын ерөнхий аудиторов тушаалд хамруулан 27 байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх гэрээг байгуулж бэлтгэл ажлыг хангалаа.

Манай байгууллагаас ЯАГ-ын “Хүндэт жуух бичиг”-ээр дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр, ахлах аудитор Д.Цэрэнханд, аймгийн ИТХ-ын “Жуух бичиг”-ээр шинжээч Э.Сүнжидмаа, Засаг даргын “Жуух бичиг”-ээр шинжээч Х.Билэгбаяр, “Алтай хотын хүндэт иргэн” тэмдгээр ахлах аудитор Ж.Бүжинханд, МНБИ-ын “Хүндэт өргөмжлөл”-өөр аудитын менежер Д.Эрдэнэчимэг, “Хүндэт тэмдэг”-ээр айдитор Г.Цэцэгмаа, байгууллагын “Шилдэр ажилтан”-аар шинжээч Г.Энхдэлгэр нарыг тодорхойлон шагналаа.

Сургалтын талаар:

Аудитор, шинжээч нараас оны эхэнд “Сургалтын хэрэгцээ тодорхойлох” саналын хуудсаар санал авч 2016 оны сургалтын төлөвлөгөөг 39 сургалтыг зохион байгуулах, улирал бүр тестын шалгалт авахаар Тэргүүлэх аудиторроор батлуулан сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг дарга аймгийн Нийгэм эдийн засгийн байдал болон Алим хөтөлбөрөөр, Шүүхээс Захиргааны ерөнхий хуулиар болон Иргэний Шүүхээр шийдвэрлэх нь сэдэвт сургалтыг зохион байгуулж 32 хүн хамрагдлаа.

Байгууллагын дотоод сургалтыг 2,3,4 дүгээр улиралын 7 хоног бүрийн баасан гарагт зохион байгуулж аудитор, шинжээч нарт 20 цагийн сургалт хамрагдсан гэрчилгээг олгосон.

ЯАГ-аас зохион байгуулагдсан 9 удаагийн онлайн сургалтанд тогтмол оролцон аудитын явцын талаар мэдээлэл хийж санал солилцож “Web site”-д цаг үеийн мэдээллүүдийг тавьсан.

ЯАГ-аас АДБОУС-ыг төрийн аудитын үйл ажиллагаанд хэрхэн нэвтрүүлэх аргачлал, шинээр боловсруулан гаргасан зарим журмын заалтуудыг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар сургалтыг зохион байгуулж, аудитор, шинжээч нарын дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Мөн САГ-аас зохион байгуулсан “Аудитад мэдээллийн технологийн ашиглах, хөгжүүлэх зарим асуудал” сэдэвт төрийн аудитын төв, орон нутгийн аудиторчуудын дунд зохион байгуулсан хэлэлцүүлэгт 3 аудитор, шинжээчийг хамруулж хамт олны санал хүсэлтийг хүргүүлсэн болно.

Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авилгын үндэсний хөтөлбөр”-ийн сургалтанд Тэргүүлэх аудитор, аудитын менежер, аудитор, шинжээч нар оролцлоо.

Захиргааны ерөнхий хуулиар аймгийн захиргааны хэргийн ерөнхий шүүгчээс сургалт авч Тэргүүлэх аудитор, аудитын менежер, аудитор, шинжээч нар бүрэн хамрагдаж чөлөөт ярилцлага хийлээ.

“Төрийн аудитын байгууллагын чадавхийг бэхжүүлэх төсөл”-өөр хийж байгаа Төрийн аудитын сургалтын тогтолцоог сайжруулах буюу мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлын хүрээнд ЯАГ-ын СУГ-аас зохион байгуулсан

сургалт, судалгаанд Тэргүүлэх аудитор, аудитын менежер, аудитор, шинжээч нар оролцож сургалтын талаар санал асуулга өгч, харилцан ярилцаж санал бодлоо солилцлоо.

Монголын Мэргэшсэн нягтлан бодогчийн институтаас зохион байгуулсан “Баруун бүсийн мэргэшсэн нягтлан бодогч нарын сургалт зөвлөгөө”-нд манай байгууллагаас 2 ахлах аудитор, 1 аудитор амжилттай оролцож спортын төрөлд 1 алт, 3 хүрэл медаль, 1 аудитор Мэргэшсэн нягтлан бодогчийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнууллаа.

Давтан аудитын талаар:

Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу “Татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, үр нөлөөт байдалд хийсэн гүйцэтгэлийн аудит, ”Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын шийдвэрийн мөрөөр давтан аудит хийлээ.

Давтан аудитаар өмнөх шийдвэрийн хэрэгжилтээс 125.0 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж, 20.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 3 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлээ.

Бусад ажлын талаар:

Аймгийн Төсөвт байгууллагаар “РИО-2016” олимпын цом аялан яваад хамт олноороо оролцон олимпын хөгжлийг дэмжих санд хандив өгч, хүндэтгэлийн дэвтэрт хамт олны дурсгалын зураг болон саналаа бичиж явууллаа.

Нийслэл, Дорноговь, Дорнод аймгийн Аудитын газраас туршлага судлан, нөхөрсөг уулзалт ярилцлага зохион байгуулж Хамрын хийдээр аяллаа.

Үндэсний аудитын газрын Тамгын газраас зарласан “Авилигагүй хамт олон” аяны хүрээнд “Гар зургийн уралдаан”, “АХА” тэмцээн, сургалтыг зохион байгуулан ажиллалаа.

Аймгийн Аудитын газарт 2016 онд төрийн аудитын үйл ажиллагаатай холбоотой 8, аудит хийлгэх тухай 11, бусад 7 нийт 26 өргөдөл хүлээн авч 24 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж 2 албан бичиг нь хугацаа болоогүй судлах шатандаа байна.

ҮАГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу ирүүлсэн судалгаа, аудитын журамд өгөх саналыг хугацаанд нь хүргүүлсэн байна.

Тухайн жилд хийсэн СТА, НА, ГА бүрд 1, 2 дугаар шатны чанарын хяналтыг хийж баримтжуулан ажилласан.

Сонгуулийн тухай хуулийн дагуу аймаг, сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвших нам эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоолоо.

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам, эвсэл тус бүрийн зарцуулах зардлын дээд хэмжээг 112.7 сая төгрөгөөр, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах дээд хэмжээг 347.7 сая төгрөгөөр тогтоолоо.
- Сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нам, эвсэл тус бүрийн зарцуулах зардлын дээд хэмжээг 85.9 сая төгрөгөөр, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах дээд хэмжээг 569.6 сая төгрөгөөр тогтоосон байна.

Нийгмийн даатгалын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Дотоод хяналт аудитын албатай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийг дүгнэж цаашид байгууллагын хамтын ажиллагаанд нөлөөлөхүйц хэд хэдэн арга хэмжээг нэмэлтээр тусгаж өглөө.

МНБИ-ын Говь-Алтай аймаг дахь салбарын удирдах зөвлөлд аудитын газрын төлөөлөл болгон Ахлах аудитор Д.Цэрэнхандыг, хяналтын зөвлөлд байгууллагын ахмад настан Р.Цанжидмааг санал болгон томилуулж жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгууллагын зүгээс санал зөвлөмж оруулан батлуулж хамтран ажиллаж байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ: САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР:

Байгууллагын 2016 онд 281.7 сая төгрөгийн орлого, санхүүжилттэй үйл ажиллагаа явуулан төсвийг зохих хууль журам, зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан. Төсвийн хөрөнгийг хэмнэх талаар УИХ, ЗГ-аас гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэн төсвийг удирдан зохион байгуулж өр, авлага үүсгэхгүйгээр 12.5 сая төгрөгийг хэмнэж ажиллалаа.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах, Төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах,

үүднээс өөрийн санхүүгийн үйл ажиллагааны зарцуулалтыг www.audit.mn сайтад тогтмол мэдээлсэн.

Төсвийн зарцуулалтын ил тод байдлыг хангуулан ажилтнуудад төсвийн талаар мэдээлэл хийж арвилан хэмнэлттэй байх талаар анхаарч санхүүгийн тайлан мэдээг зохих цаг хугацаанд нь гаргаж хэрэглэгч болон удирдлагыг санхүүгийн мэдээллээр бүрэн хангаж ажиллалаа. Мөн санхүүгийн тайланг улирал тутамд хамт олны хуралд танилцууллаа.

Батлагдсан санхүүжилтийн хэмжээнд 2016 онд гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар аймгийн 18 суманд ажилласан ажилтнуудын албан томилолт, шатахууныг цаг хугацаанд нь бүрэн гаргаж өгч аудитыг хурдан шуурхай хийж гүйцэтгүүллээ.

НАЙМДУГААР БҮЛЭГ: ДҮГНЭЛТ, САНАЛ:

Говь-Алтай аймгийн Аудитын газар нь Санхүүгийн тайлангийн аудитыг 196 санхүүгийн тайланд хийж дүгнэлт гаргаж, нэгдсэн удирдамжаар хийсэн гүйцэтгэлийн болон нийцлийн аудитыг төлөвлөгөөт хугацаанд хийн хүргүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөөг 110 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Тухайн жилд хийсэн аудитаар өгсөн шийдвэрээс 597.2 сая төгрөгийн акт, 25,376.6 сая төгрөгийн албан шаардлага, өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрээс 201.8 сая төгрөгийн акт, 7.2 сая төгрөгийн албан шаардлага, 5 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тухайн жилд 6,624.5 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 194 санхүүгийн бус үр өгөөж бүртгэж, өмнөх оноос шилжин ирсэн үр өгөөжийн хамт 4,687.9 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөжийг харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж 1 төгрөгт ногдох үр өгөөжийг 17.24 төгрөгт хүргэн ажиллалаа.

Манай Аудитын газар нь бие даасан ажлын байртай тул засвар үйлчилгээ, аж ахуй хариуцсан нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтан зайлшгүй шаардлагатай байгааг харгалзан үзэж 1 орон тоо, төсвийн хамт шийдвэрлэж өгнө үү.

Та бүхний ажилд амжилт хүсье.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР**